



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

┌ Мэдээ, тайлангийн маягт, зааварт ┐
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын захиргааны статистикийн болон бүртгэлийн дараах маягтууд, түүнийг нөхөх зааврыг хавсралтын дагуу баталж, мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар /З.Мэндсайхан/-т зөвшөөрсүгэй. Үүнд:

- Дуусаагүй барилга байгууламжийн 20... оны жилийн бүртгэл (ТӨ-1)
- Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-2)
- Биет бус хөрөнгийн бүртгэлийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-3)
- Түрээслүүлсэн үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-4)
- Түүх, соёлын дурсгалт зүйлсийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-5)
- Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болгосон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-6)
- Гадаад зээлийн эх үүсвэрээр бий болгосон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-7)
- Гадаадын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-8.1)
- Дотоодын буцалтгүй тусламж, хандив, бэлэглэлээр бий болсон үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-8.2)
- Бүртгэлд тусгаагүй үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-9)
- Дутагдуулсан үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-10)
- Маргаантай үндсэн хөрөнгийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-11)
- Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн бүртгэлийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-12)
- Улсын чанартай авто замын 20... оны жилийн мэдээ (ТӨ-13.1)
- Улсын чанартай гүүрний 20... оны жилийн мэдээ (ТӨ-13.2)
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 20... оны жилийн мэдээ (ТӨ-14)
- Радио долгионы 20... оны жилийн мэдээ (ТӨ-15)

142623100186

- Хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэл (ТӨХ-1)
- Байгууллагын эзэмшил /ашиглах/ газрын бүртгэл (ТӨХ-2)
- Барилга байгууламжийн бүртгэл (ТӨХ-3)
- Барилга байгууламжийн хийц, хэмжээсийн бүртгэл (ТӨХ-3.1)
- Байгууллагын мэдлийн нийтийн эзэмшлийн байгууламжийн бүртгэл (ТӨХ-4)
- Машин тоног төхөөрөмжийн бүртгэл (ТӨХ-5)
- Тээврийн хэрэгслийн бүртгэл (ТӨХ-6)
- Тавилга, эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн бүртгэл (ТӨХ-7)
- Үндсэн сүргийн мал, амьтдын бүртгэл (ТӨХ-8)
- Худаг, услалтын системийн бүртгэл (ТӨХ-9)
- Оюуны өмчийн бүртгэл (ТӨХ-10)
- Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн 20... оны жилийн дэлгэрэнгүй мэдээ (ТӨХ-11)

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Мэдээ, тайлангийн маягт, зааварт өөрчлөлт оруулах тухай" Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар /хуучнаар/-ын даргын 2016 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/231 дугаар тушаалаар зөвшөөрсөн Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн захиргааны статистик мэдээллийн маягт болон Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягт, зааврыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалаар зөвшөөрөгдсөн маягуудын үзүүлэлтүүдийн дагуу мэдээллийг авч, холбогдох тооцоо, судалгаанд ашиглаж байхыг Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газар /Э.Эрдэнэсан/-т даалгасугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Дотоод аудит, мониторингийн хэлтэс /Б.Саранчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



А.АРИУНЗАЯА